



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А138

Улаанбаатар хот

### Г “Найрсаг Улаанбаатар” нийгмийн аян Г зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.7.1, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/51 дүгээр захирамж, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд бүх төрлийн үйлчилгээнд найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлж, хотын соёлыг дэлгэрүүлэх, иргэдийн харилцаа хандлага, төрийн болон нийтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Найрсаг Улаанбаатар” нийгмийн аяныг “Жи Си Ай Монгол” ТББ-тай хамтран хэрэгжүүлэх гэрээг хууль журамд нийцүүлэн байгуулахыг Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн /Э.Болорцэцэг/-д даалгасугай.

2. Гэрээт ажлын төлбөр болох 9,900,000 /Есөн сая есөн зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА

